

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2016 оны 11 дүгээр сарын 11



Тус дүүргийн Дотоод аудитын хорооны хурлаар Дотоод аудитын албаны 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн үр дүнгийн гэрээ болон 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан ажилласан.

Тус албанаас 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт, аудитын удирдамжийг Дүүргийн Засаг дарга болон албаны даргаар батлуулан дараах байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт, аудит хийж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа. Үүнд:

2015 оны 3 дугаар улиралд тус дүүргийн сургуулийн өмнөх боловсролын 31, 56, 70, 154 дүгээр цэцэрлэгүүд, “Таны итгэл”, “Мөнх үйлстэн” өрхийн эрүүл мэндийн төвүүдэд аудит хийгдсэнтэй холбогдуулан өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт, үүрэг даалгаврын биелэлтэнд хяналт шалгалтыг 2016 оны 2 дугаар сард хийж ажилласан. Дээрх байгууллагууд нь зөвлөмжийн дагуу хэрэгжүүлбэл зохих ажлыг хангалттай биелүүлэн ажилласан бөгөөд хэрэгжүүлсэн ажлын тайлан, албан бичгийг заасан хугацаанд ирүүлсэн болно.

Тус дүүргийн 17, 18, 19 дүгээр хороодод хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж буй Найши трейд ХХК-ийн хог тээвэрлэлтийн график, маршрут, гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Аудитын явцад хог тээвэрлэлтийн түүврийн аргаар хэсэгчилсэн хяналт хийж, хороодын удирдлага, хэсгийн ахлагч, холбогдох байгууллага, мэргэжилтнээс тодруулга, тайлбар гаргуулж, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр байгуулагдаж 2015 оны 12 дугаар сард ашиглалтад орсон 224 дүгээр цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагаа, Хүүхдийн номын өргөө ОНӨҮГ-ын санхүү, бүртгэлдаудит хийж дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн ба Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, заавар журам, стандартын хэрэгжилтийн байдал, илэрсэн зөрчлийг арилгуулах, үндсэн үйл ажиллагаа болон санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.



Мөн дүүргийн 5, 33, 39 дүгээр цэцэрлэгүүдийн 2014, 2015 оны үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, түүний үр дүн, төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа, төсвийн санхүүжилт, зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлангийн гаргалт, байгууллага, иргэдийн хандив, тусламж болон төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн ашиглалт, үр дүн, дотоод хяналтын тогтолцоо, шилэн дансны тухай хууль, дүрэм журам, стандарт, гэрээний хэрэгжилтийг хангасан байдал, эрхлэгч, нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт, төсөвт батлагдсан дулаан, цахилгаан, цэвэр бохир усны зардлын үнэ, тарифын үндэслэл, тооцооллыг нягтлан шалгаж аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж цэцэрлэгийн удирдлагуудад аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалын талаар дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж, зөвлөгөө өгч ажилласан.

2015 оны сүүлийн хагас жилд тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн зарим иргэдэд хандив, тусламж, дэмжлэг олгогдсон байдалд 2016 оны 3 дугаар сард хяналт шинжилгээ хийж, тусламж, дэмжлэг хүртсэн иргэдийн ахуй амьдрал, олгосон тусламж дэмжлэгийн үр өгөөжтэй танилцах, олгогдсон хандив, тусламж, дэмжлэгийн үр нөлөөтэй байдал зэрэг асуудлын хүрээнд сэтгэл ханамжийн түүвэр судалгаа явуулж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэдэд

олгосон хандив, тусламж, дэмжлэгийн байдал, түүний зарцуулалт, үр дүнд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг гаргаж Засаг даргын Тамгын газрын удирдлагуудад хүргүүлж ажилласан.

Тус албанаас удирдамжийн дагуу 5 дугаар сарын 10-аас 17-ны өдрүүдэд дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэдээс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний саналд иргэний оролцоог хангасан байдал, саналын хуудсыг шивэх, нэгтгэх ажил хэрхэн явагдаж байгаад хяналт шалгалт хийж ажилласан. Хяналт, шалгалтыг хороодын хэсэг тус бүрээр иргэдээс ирүүлсэн саналын хуудаст шинжилгээ хийж санал асуулгын хуудсанд саналыг бичсэн байдал, бодитой тусгасан эсэх, санал асуулгын хуудсыг компьютерт үнэн зөв шивсэн эсэх, нэгтгэл хийсэн байдал, урьд оны зөрчилд дүгнэлт хийж ажилдаа хэрэгжүүлсэн байдал гэсэн асуудлын хүрээнд явуулж илэрсэн зөрчилтэй асуудал, дүгнэлт, зөвлөмжийг гаргаж дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагуудад хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд 7-19 дүгээр хорооны нутаг дэвсгэр буюу гэр хорооллын гудамжинд явган хүний зорчих зам, гэрэлтүүлэг, явган шат, тоглоомын талбай, цэцэрлэгийн өргөтгөл, ус урсан өнгөрөх суваг шуудуу гэх мэт ажлыг иргэдээс ирүүлсэн саналын дагуу хийж гүйцэтгэсэн ажилд 2016 оны 4 дүгээр сар, 7 дугаар сар, 10 дугаар сард тус тус хяналт шалгалт хийж зарим ажлын гүйцэтгэл, ашиглалт, хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргаж дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан.



Дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Ногоон дүүрэг” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх явц, орчны тохижилт, цэвэрлэгээний үйл ажиллагаанд 2016 оны 4, 5, 6, 8 дугаар сард хяналт шалгалт хийж цаашид хэрэгжүүлэх ажлын талаар газар

дээр нь заавар зөвлөгөөг өгч ажилласан. Хяналт шалгалтын ажлын тайландсургууль, цэцэрлэг тус бүрийн одоогийн нөхцөл байдал, өгсөн заавар зөвлөгөө, тайлбар зургийгхавсралтаар гаргаж Дүүргийн удирдлагуудад танилцуулсан.

Чингэлтэй дүүрэг дэх “Чингэлтэйд үйлдвэрлэв” буюу “Өрхийн үйлдвэрлэлийн бараа, үйлчилгээ худалдах төв”-үүдийн үйл ажиллагаа хамруулан хяналт шалгалт хийж Дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээ бусад холбогдох хууль тогтоомж, заавар журам, стандартын хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар дүгнэлт, зөвлөмжийг гаргаж дүүргийн удирдлагуудад танилцуулсан болно.


Мөндүүргийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу дүүргийн 2014-2016 оны Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Бизнес Инкубатор төвөөсхэрэгжүүлж буйжиг, дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн нүүдлийн ажлынбайрны үйл ажиллагааг хамруулан тэдгээрийн ашиглалт, үр нөлөөтэй байдалд хяналт шалгалтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

Сангийн яам болон холбогдох бусад дээд байгууллагаас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн: Үүнд:

Сангийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн удирдамжийн дагуу Чингэлтэй дүүрэг дэх Өмч, газрын харилцааны албаны газрын төлбөрийн орлого бүрдүүлэлт, санхүүгийн үйл ажиллагаа, иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, өр авлага үүссэн ба барагдуулсан байдал, өр авлагыг данс бүртгэлд тусгасан байдал, өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалтад хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгч хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн зөвлөмж өгч, тайланг нийслэлийн Дотоод аудитын албаар дамжуулан Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалт, Дотоод аудитын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

Сангийн сайдын 2016 оны 8 дугаар сарын 1-ний өдөр баталсан “Онцгой байдлын ерөнхий газар болон түүний харъяа байгууллагуудын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж”-ийн хүрээнд дүүргийн Дотоод аудитын албанаас холбогдох үйл ажиллагаанд шалгалт хийж тайлан, дүгнэлт, зөвлөмжийг танилцуулан ажиллаж байна.

График: 2014, 2015, 2016 оны хяналт шалгалт, аудитын харьцаа:



Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шилэн дансны тайланг хагас, бүтэн жилээр Нийслэлийн Дотоод аудитын албанд хүргүүлэн ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллага, ОНӨААТҮГ-уудын мэдээлэлд тогтмол хяналт тавьж ажилласан. Үүнд: Дүүргийн 14 сургууль, 24 цэцэрлэг, орон нутгийн 8 байгууллага, ОНӨААТҮГ-ын 2 байгууллага нийт 48 байгууллагыг хамруулж shilendans.gov.mn цахим хуудаст төсвийн төсөл, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн хуваарь түүний гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэлд хяналт тавин ажиллалаа.

Дээрх байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хариуцсан албан хаагч нарт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, шинээр байгуулагдсан байгууллагуудыг шилэн дансанд тухай бүр нь байршуулж санхүү бүртгэлийн ажилтан нарт зөвлөгөө



өгч ажилласан бол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 34 хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг, 16 өрхийн эрүүл мэндийн төвийг шилэн дансанд бүртгүүлэхээр холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж шилэн дансны мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Шилэн дансны 2015 оны үзлэг тайлан болон 2016 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар Нийслэлийн Аудитын газраас хийсэн шалгалтаар зөрчил илрээгүй болно.

Дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлыг 4дүгээр сарын 22-нд зохион байгуулж Нийслэлийн аудитын шалгалтаар зөрчилтэй гарсан 17, 23 дугаар сургуулиуд, 37, 70 дугаар цэцэрлэгүүдийн удирдлагуудыг оролцуулан цаашид анхаарч ажиллах асуудлуудын талаар зөвлөгөө өгч ажилласан болно.

Бусад ажил болон дотоод үйл ажиллагааны талаар хийж гүйцэтгэсэн ажлын талаар:

Тус албанаас 2016 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайлан, 2016 оны нийгэм эдийн засгийн зорилтын хэрэгжилт, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн дагуу тус албаны 2015 оны захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх ажлыг 2016 оны 5 сарын 26-27 ны өдрүүдэд "e.doc.ub.gov.mn" сайтад байршуулсан.

Сангийн яамны Төсвийн хяналт эрсдэлийн удирдлагын газар, Нийслэлийн Дотоод аудитын алба болон дүүргүүдийн Дотоод аудитын албадын хооронд зохион байгуулагдсан “ДОТООД АУДИТ-2016” спортын тэмцээнд амжилттай оролцож багаараа II байр эзэлсэн.





Мод тарих үндэсний өдрөөр 5 дугаар сард ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн ногоон байгууламжийн талбайд мод, бут, сөөгийн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн тарилтыг хийж, нийт 25 бургас, 10 улиас тарьж, 10 дугаар сард орчны хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан

ажилласан ба тайлан мэдээг дүүргийн Дэд бүтэц тохижилтын хэлтэст хүргүүлсэн.

Тус албанаас дүүргийн Худалдан авах ажиллагааны албатай хамтран Дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу 2, 4 дүгээр саруудад бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг хийж дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт Гэсэр сүмийн уулзвараас Баянбүрдийн тойрог хүртлэх явган хүний зам, талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан. Цэвэрлэгээнд тухайн орчны аж ахуйн нэгж байгууллагуудад өөрийн эзэмшлийн талбайг цэвэрлэх үүргийг өгч хамтран ажилласан.

2016 оны 5 дугаар сард Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон зохион байгуулж ажилласан ба тайлан мэдээг Дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн бол 2016 оны аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогод хамрагдаж гэрчилгээ авсан.

Нийслэлийн аудитын газраас тус албаны 2015 оны санхүүгийн тайлан болон санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийсэн ба аудитын дүгнэлтээр зөрчилгүй гарсан. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөгдөн батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Олон улсын байгууллагын хамтарсан Иргэний төсвийн хэрэглүүрийг хэрхэн ашиглах талаарх сургалт, Дотоод аудитын чадавхийг бэхжүүлэх төсөл болон Монголын Дотоод Аудиторуудын Холбооноос

зохион байгуулсан сургалт, байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны сургалтад албаны албан хаагчид хамрагдсан.

Төсвийн тухай хууль болон Дотоод аудитын дүрэмд зааснаар Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, байцаагчийн эрхийг албаны дарга болон нэр бүхий 2 байцаагчид Сангийн сайдын 2016 оны 37 дугаар тушаалаар үнэмлэх, тэмдгийн хамт олгосон ба эдгээр байцаагч нар нь хөрөнгө орлогын мэдүүлгийг цаг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн.

ХЯНАСАН:

ДАРГА

Ц.ЖАРГАЛТАЙ

ТАЙЛАН БИЧСЭН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЖМЯНГАН